

Golomt Capital®

БОНДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2025.09.17



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Номад	2026.04.07	5.125%	5.81%
Монгол 27	2027.07.07	3.50%	5.69%
Хүннү	2028.01.19	8.65%	5.68%
Монгол 29	2029.06.05	7.875%	5.89%
Монгол 30	2030.02.25	6.625%	6.17%
Монгол 31	2031.07.07	4.45%	6.41%

Эх сурвалж: Bloomberg

Монгол Улсын Засгийн газар бондуудын өгөөж 5.68%-6.41% хооронд хэлбэлзэж байна.



КОМПАНИЙН БОНД (АМ.ДОЛЛАР)

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Голомт Банк (GLMT)	2027.05.20	11.00%	8.15%
МИК (MIK)	2027.01.18	11.50%	12.01%
TDBM	2027.12.23	8.5%	8.94%
DBM	2026.03.07	11.00%	6.32%

Эх сурвалж: Bloomberg

Компанийн ам.долларын бондуудын өгөөж 6.32%-12.01%-ийн түвшинд хэлбэлзэж, эрсдэлийг давж өндөр өгөөж хайж буй хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна. Голомт Банк олон улсын зах зээлд жилийн 11%-ийн хүүтэй, 2027.05.20-нд хаагдах 300 сая ам.долларын бондыг амжилттай гаргасан бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаагаар худалдан авах боломжтой хэвээр байна.

Golomt Capital

2021-2024 он

19%

дундаж хүү

Нийт

3.000

хөрөнгө оруулагч

Нэг хөрөнгө оруулагч

95 сая ₮

хүртсэн өгөөж



Одоо

₮20%

БОНД АВАХ
₮10 сая



жишээ

ХҮРТЭХ
₮2 сая
ӨГӨӨЖ

AM.ДОЛЛАРЫН БОНДЫН СУУРЬ МЭДЭЭЛЛҮҮД

Ам.долларын бондод хөрөнгө оруулах алтан үе ирээд байна

График 1. 10 жилийн хугацаатай АНУ-ын ЗГ-ын өгөөж



АНУ-ын Төв банк 9-р сарын 17-ны ээлжит хурал дээр бодлогын хүүгээ бууруулах магадлал 100% хүрээд байна. Сүүлийн нэг сарын хугацаанд АНУ-ын 2 жилийн хугацаатай ЗГ-ын бондын өгөөж 0.5%-иар буурсан бол Монголын ЗГ болон ОУ-ын зах зээл дээрх корпорацын бондуудын өгөөж тогтвортой хэвээр байна. Хэрэв ФРС 9-р сарын 17-нд бодлогын хүүгээ бууруулбал, хөгжиж буй зах зээлийн бондуудын өгөөж цаашид буурах нь тодорхой. Өөрөөр хэлбэл ам.долларын бондуудын ханш өсөх хүлээлттэй байна.

График 2. Ам.долларын индекс



Ам.долларын индекс 99 түвшнээс эсэргүүцэл аван доош унаж байна. Мэдээж бодлогын хүү буурах хүлээлт нэмэгдсэнтэй зэрэгцэн доллар зарах үзэгдэл нэмэгдэж байна. Ам.долларын индексийн дараагийн хүрэх зорилт 96.3



ДОТООДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ШУНХЛАЙ БОНД 2.0 ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН 2-Р ТРАНЧИЙН ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА ЭХЭЛНЭ


"Шунхлай" ХХК-ийн нийтэд санал болгон гаргасан "Шунхлай бонд 2.0" өрийн хэрэгслийн хоёрдугаар транчийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцсон Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 1/3458 тоот албан бичгийн дагуу 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 10 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгслийн хоёрдугаар транчийн хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэхээр боллоо.

Биржийн бус зах зээлийн бондын өгөөжийн муруй

Бондын өгөөжийн муруй нь зах зээлд гарч буй бондуудын хугацаа болон өгөөжийн хамаарлыг нь илтгэдэг. Өгөөжийн муруйг дараах зорилгоор ашиглах боломжтой. Үүнд:

- Үнэт цаасны өгөөжийн хувь үнэт цаасны хугацаанаас хамааран хэрхэн ялгаатай тогтож байгааг мэдэх
- Шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тогтоох жишиг хувь болох
- Бусад бондын өгөөжтэй харьцуулан шийдвэр гаргах боломжийг олгодог юм.

График 2. Бондын өгөөжийн муруй (2024.10-р сард бодлогын хүү өөрчлөгдсөнөөс хойш)



**ЗГҮЦ-НЫ АРИЛЖАА
3 ЖИЛИЙН ХУГАЦААТАЙ
БОНД ЗАХИАЛГА
АВЧ БАЙНА**

8083-7744 | 8665-4422 | 8665-1177